

**МИАТ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОН АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН ХАРИЛЦАН
ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

2022 оны 01 сар 29 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас МИАТ Хувьцаат Компани /цаашид “Компани” гэх/ нөгөө талаас Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /цаашид “Алба” гэх/ хамтран ажиллах талаар дор дурьдсан асуудлаар харилцан тохиролцож энэхүү санамж бичгийг үйлдэв.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санамж бичгийн зорилго нь Иргэний нисэхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4, 42 дугаар зүйлийн 42.2, 45 дугаар зүйлийн 45.1.5 хэсэг, Иргэний нисэхийн багц дүрэм болон Олон Улсын Иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ын баримт бичгийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулах болон агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны үед хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2. Хамтын ажиллагаа нь хуулиар хориглоогүй асуудалд ил тод нээлтэй байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан хүндэтгэлтэй хандах зарчимд тулгуурлаж үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний заалтыг удирдлага болгоно.

Хоёр. Аюулгүй ажиллагааны мэдээлэл дамжуулах

2.1. Компани нь өөрийн агаарын хөлгийн нислэгийн явцад гарсан аливаа осол, зөрчлийн талаар мэдээлэл авсан эсхүл мэдсэн тохиолдолд Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 40.1-ын заалт, ИНД-12 болон шинжлэн шалгах ажиллагааны дүрмэнд заасны дагуу нэн яаралтай мэдээлнэ.

Утас: 95953399
Цахим шуудан: aaib@aaib.gov.mn

2.2. Алба нь компанитай холбогдох агаарын хөлгийн осол, зөрчлийн аливаа мэдээллийг дараах хаягаар мэдэгдэнэ.

Утас: (976) 7128-4038 (ажлын цагаар), 70049999 /Аюулгүй ажиллагааны мэдээлэл хүлээн утас 283070 (онцгой байдлын үед)

Цахим шуудан: aachnaba@miat.com

2.3. Компани нь осол,ноцтой зөрчилд өртсөн агаарын хөлгийн бүхээгт байгаа аюултай ачааны талаарх мэдээллийг нэн даруй Албанд мэдэгдэнэ.

Гурав. Шинжлэн шалгах чиглэлээр хамтран ажиллах

3.1. Агаарын хөлгөөр тээвэрлэх тухай.

- Агаарын хөлгийн осол, зөрчил болсон газар шинжлэн шалгах албанаас томилогдсон баг бүрэлдхүүн, тэдний ачаа, тээшийг өөрийн агаарын хөлөг нисэж буй чиглэлд явуулах ажлыг яаралтай зохион байгуулах,

3.2. Нотлох баримтыг хадгалах, хамгаалах тухай.

- Осол, зөрчлийн газраас ирсэн агаарын хөлөг түүний том оврын эд анги, нотлох баримтыг шинжлэн шалгах ажиллагаа дуустал нууцлалтай хадгалах, хамгаалах боломжоор хангах, шинжилгээнд явуулах, тээвэрлэх, ажиллагааг талууд хамтран шийдвэрлэнэ.

Үүнд:

Компани нь:

- Осол, ноцтой зөрчилд өртсөн агаарын хөлөг түүний том оврын эд анги, нотлох баримтыг ангар болон тусгайлан хадгалах өрөөнд хадгалж хамгаална.
- Тусгайлан гаргасан өрөөнд зөвхөн эрх бүхий шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагч нарыг нэвтрүүлнэ.
- Тусгайлан гаргасан өрөөнд нууцлалын код болон бусад нэвтрэх боломжоор хангаж өгнө.
- Хэрэв ангар болон тусгайлан гаргасан өрөөнд гал түймэр, цахилгаан, үер усны болон бусад аюулын эрсдэл үүссэн тохиолдолд Албанд яаралтай мэдэгдэж нүүлгэн шилжүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.

Алба нь:

- Осол, ноцтой зөрчилд өртсөн агаарын хөлөг түүний том оврын эд анги, нотлох баримтыг хадгалах хамгаалуулах талаар урьдчилан компанид мэдэгдэж баталгаажуулна.
- Эрх бүхий шинжлэн шалгагч нар нь ангар болон хадгалалтын өрөө рүү нэвтрэхдээ компанид урьдчилан мэдэгдэнэ.
- Ангарт байрлуулсан агаарын хөлөг болон тусгайлан гаргасан өрөөнд нууцлалын код болон бусад эрхээр нэвтрэнэ.
- Шинжлэн шалгах ажиллагааны явцын болон дуусгавар болох үед нотлох баримтыг холбогдох байгууллагад шилжүүлэх шийдвэрийг гаргана.

- Хэрэв ангар болон тусгайлан гаргасан өрөөнд гал түймэр, цахилгаан, үер усны болон бусад аюулын эрсдэл үүссэн тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.

3.3. Нөөц шинжлэн шалгагч

- Алба нь Чикагогийн конвенцийн Хавсралт 13, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах дүрмийн хүрээнд шаардлагатай тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаанд нөөц шинжлэн шалгагчийг татан оролцуулж болно.
- Шинжлэн шалгах хамтын ажиллагааны үед нөөц шинжлэн шалгагч нь хууль, дүрмийн дагуу ажил үүргийн хүрээнд харилцан итгэлцэл, албан ёсны үүрэгт захирагдах ёстойг хүлээн зөвшөөрөх.
- Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд томилогдсон нөөц шинжлэн шалгагч нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.
- Шинжлэн шалгах ажиллагааны үед нөөц шинжлэн шалгагч осол, ноцтой зөрчил, зөрчилтэй холбоотой аливаа мэдээллийн нууцлалыг шинжлэн шалгах ажиллагаа эцэслэн дуусах хүртэл хугацаанд хадгалах үүрэгтэй.
- Шинжлэн шалгах ажиллагаанд оролцож санал бодлоо илэрхийлсэн, осол, зөрчлийн талаар мэдээлэл өгсөн аливаа этгээдийг буруутгахгүй гэдэгт талууд санал нийлнэ.

3.4. Мэдээлэлээр хангах тухай

- Алба нь Компанийг осол, зөрчлийн талаар гарсан тайлан, дүгнэлт, аюулгүй ажиллагааны зөвлөмж, холбогдох мэдээллээр хангана.
- Шинжлэн шалгах ажлын явцад нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах үүднээс Албанаас компанид яаралтай арга хэмжээ авах, зөвлөмж хэрэгжүүлэх мөн бусад холбогдох мэдээллээр хангана.
- Компани нь аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргаснаас хойш 90 хоногийн дотор Албанд зөвлөмжийн дагуу авсан эсхүл авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай хариуг ирүүлнэ.

Дөрөв. Бусад харилцаа

4.1. Энэхүү харилцан ойлголцох санамж бичгээр зохицуулагдах бүх үйл ажиллагаа нь Албаны дарга болон Компанийн гүйцэтгэх захирал нарын хоорондын гэрээ хэлэлцээрээр зохицуулагдана.

Тав. Зардал шийдвэрлэх

5.1. Урьдчилан тохиролцсоноос бусад тохиолдолд талуудын харилцан үйл ажиллагаа нь үнэ төлбөргүй байна.

5.2. Аль нэг талаас гаргасан хүсэлтийн дагуу талууд гарах зардлыг урьдчилан харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

Зургаа. Санамж бичгийн хүчинтэй хугацаа ба түүнд оруулах өөрчлөлт

6.1. Энэхүү санамж бичигт гарын үсэг зурсан өдрөөс хойш эхлэн гурван жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Энэхүү санамж бичгийг цуцлах, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулах тухайгаа аль нэг тал нь нөгөө талдаа хуанлийн 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Батлав

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ,
ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН
ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА



Ж.ЦОЛМОН

Батлав

МИАТ ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Т.ТЭЛМЭН